

## **Монголын банкны системийн шинэтгэлийн хэрэгжилт**

### **Implementation of the Mongolian Banking System Reform**

С. Отгонсүрэн<sup>1</sup>

Хураангуй

Монгол Улсын банкны тогтолцоон дахь арилжааны банкны тогтвортой байдал нь эдийн засгийн өсөлт хөгжилд шууд нөлөөтэй үзүүлэлт юм. Зарим арилжааны банкуудын эзэмшигчдийн хариуцлагагүй шийдвэр, зохисгүй үйл ажиллагааны үрээр дампуурал зарлахад бусад банк болон санхүүгийн салбар бүхэлдээ ганхаж хүндрэлд ордог. Монгол Улсын эдийн засгийн тогтвортой байдалд банкны салбарын үзүүлэх нөлөө маш чухал байр суурьтай учир банкуудыг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулах замаар эзэмшил, удирдлагын төвлөрлийг бууруулах, банкны системийг эрүүлжүүлэх бодлогын хүрээнд Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Тус хуулийн өөрчлөлт хэрхэн хэрэгжиж, эдийн засгийн өнөөгийн нөхцөлд ямар давуу тал бий болж буйг, цаашид ямар арга замаар хуулийн хэрэгжилт үргэлжлэхийг, иргэд хөрөнгө оруулагчдын банкны шинэтгэлийн хөтөлбөр дэх оролцоо, тус хөтөлбөрийн хүлээлтийн үр дүнг тодорхойлох хугацаа болсон гэж үзэж байна.

*Түлхүүр үгс:* нээлттэй хувьцаат компани, засаглал, шинэчлэлт, төвлөрөл

#### **Abstract**

The stability of commercial banks in Mongolia's banking system is an indicator which has a direct impact on economic growth and development. When some commercial banks declare bankruptcy due to irresponsible decisions and inappropriate actions by their owners, other banks and the financial sector also uptight and fluctuate. Since the impact of the banking sector on the stability of Mongolia's economy is very important, amendments have been made to the Banking Law in the framework of the policy to reduce the concentration of ownership and management and make the banking system healthy by reorganizing banks into open joint-stock companies. It is considered that it is time to determine how the amendments to the law are to be implemented, what advantages are created in the current economic conditions of Mongolia, by which ways the law implementation will continue in the future, the participation of investors and citizens in the banking reform program, and the expected results of this program.

*Keywords:* open joint-stock company, governance, reform, centralization

---

<sup>1</sup> ШУТИС-ын харьяа Эрдэнэт цогцолбор дээд сургууль, НББ-ийн тэнхим  
E-mail: otgonsuren@erdenetis.edu.mn

### Удиртгал

Монгол Улсад эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлт хийгдсэнээр банкны хоёр шатлалт тогтолцоо бий болж бизнес, арилжааны 35 орчим банк шинээр байгуулагдсан хэдий ч 20 орчим банк буюу 50-иас дээш хувь нь дампуурсан байна. Эдгээр банкуудын өр төлбөрөө хариуцах чадваргүй болох гол шалтгаан нь тухайн банкны өмчлөлтэй шууд холбоотой байсан бөгөөд банкны удирдлагын зохистой байдал алдагдсан явдал байсан. Банкны хувь эзэмшигчид банкны гүйцэтгэх удирдлагад шууд нөлөөлөн, давуу эрх өөртөө бий болгон ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэрүүд гаргасны улмаас санхүүгийн хүндрэлд өртөн, төлбөрийн чадваргүйд хүрч, активын чанарыг дордуулах үндэслэлийг тавьсан байдаг.

Банкны дэд бүтцийн нэг чухал элемент нь хууль эрх зүйн орчин юм. Банк нь маш олон субъектуудын ашиг сонирхлын цэг байдаг учраас хуулийн хатуу зохицуулалт шаардана. Нэг банк дампуурахад олон мянган харилцагч, хадгалуулагчийн эрх ашиг хөндөгдөнө. Иймд банкуудын үйл ажиллагааны цар хүрээ, чиглэл бусад хуулийн этгээд, иргэдтэй харилцах эрх зүйн үндсийг хуулиар нарийвчлан тогтоож өгнө (Цэрэнтоогоо, 2013).

Аливаа улс орны хувьд банк нь өөрөө эдийн засгийн гол хөдөлгөгч хүч болдог бөгөөд мөнгө, санхүүг төвлөрүүлэн хуваарилагч болохын хувьд тогтвортой, өсөлттэй, найдвартай үйл ажиллагаатай байх шаардлагатай. Цаашид улсын хэмжээнд банкны тогтолцоонд үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкуудыг өр төлбөрийн хариуцлагын чадваргүй болохоос сэргийлэх нэг чухал арга нь банкны хувьцаа эзэмшигчдийн тоог нэмэгдүүлэх замаар эзэмшлийн

төвлөрлийг бууруулж, үйл ажиллагааг нь нээлттэй, ил тод засаглалтай болгох явдал юм.

Олон улсын түвшинд банкны салбарын өмчлөлийн байдлыг төрийн, хувийн өмчийн, гадны банк гэсэн өмчлөлөөр ихэвчлэн судалсан байдаг. Энэтхэгт хөдөө аж ахуйн салбараа дэмжих зорилгоор 1980-аад онд өөрийн хөрөнгийн хэмжээгээр нь банкуудыг зэрэглэн төрийн өмчид авч байсан ба төрийн өмчийн банкаар дамжуулан хөдөө аж ахуйн салбарт зээл олгож эхэлсэн байна. Гэвч зээл олголтын түвшин ихэссэн ч эдийн засгийн өсөлтөд нөлөөлөөгүй гэсэн үр дүн гарсан байдаг (La Porta, Lopez-de-Silanes, & Shleifer, 1999). Банкны салбарт хийсэн бусад судалгаануудаас харахад хөгжиж буй болон аж үйлдвэржсэн орнуудад банкны өмчлөлийн асуудал хэр нөлөөтэй байдгийг авч үздэг. Жишээлбэл Испани улс дахь банкны судалгаанд өмчлөл төвлөрсөн үед гол хувьцаа эзэмшигч буюу хяналтыг гартаа авсан эзэмшигч болон жижиг хувьцаа эзэмшигчдийн хооронд зөрчлөөс зөрчилдөөн рүү шилждэг байна. Томоохон хувьцаа эзэмшигчид өөрсдийн ашиг сонирхлыг төлөөлж, нийт хувьцаа эзэмшигчдийн зардлаас өөрсдийн эрх ашигт нийцсэн шийдвэрийг хэрэгжүүлдэг. Харин цөөнхийн хувьд хяналтын багцыг эзэмшигчид тэдгээрийн саналыг зөвшөөрөх эсэх нь тодорхойгүй байдалтай тулгардаг байна. Энэ нь томоохон хувьцаа эзэмшигчид цөөнхийн хувь эзэмшлийг өмчлөхөд хүргэдэг бөгөөд хяналтын хувьцаа эзэмшигчдийн зах зээлийн сахилга бат улам суларсаар байдаг байна. Корпорацийн хяналтыг зохицуулах, хууль эрх зүйн тогтолцоо сул байгаа нь үүнд нөлөөлж байна гэж дүгнэсэн байна (La Porta нар, 2002).

Өмчлөлийн төвлөрлийн бас нэг болзошгүй үр нөлөө нь банкны санхүүгийн тайлан. Хяналтын хувийг эзэмшигч нь нягтлан бодох бүртгэлийн тайланг хянадаг тул (экспроприаци хийх хүчтэй оппортунист хөшүүрэгтэй) өмчлөлийн маш хүчтэй боломжтой гэдгийг цөөнхийн хувьцаа эзэмшигчид зөвшөөрч нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн чанарт өндөр хүлээлт өгөхгүй гэж таамаглаж байна. Хяналтын эрх бүхий өмчлөгчдийн гаргаж буй орлогын тайлан дахь орлогын мэдээлэл нь итгэл үнэмшил багатай гэж цөөнх үздэг төдийгүй, өмчлөлийн төвлөрөл, орлогын мэдээлэл хооронд сөрөг хамаарал үүсэх төлөвтэй байна гэж Зүүн Азийн 7 улсын эдийн засагт хийсэн судалгаагаар дүгнэсэн байна (Fan & Wong, 2002).

Дээрх судалгаануудаас харахад банкны өмчлөлийн хэт төвлөрөл нь зохистой бус байдаг төдийгүй, банкны салбарыг хянан зохицуулахад, онцлогт нь тохирсон эрх зүйн сайн тогтолцоо бүрдүүлэх нь нэн чухал асуудал юм.

Монголбанкнаас Банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөрийг боловсруулж 2020-2023 онуудад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нэг талаас банкны салбарын өөрийн хөрөнгө нэмэгдэн эрүүлжиж, эрсдэл даах чадвар сайжирч, өмчлөл нь олон улсын жишгийн дагуу олон нийтийн өмчийн хэлбэрт шилжиж, банкуудад тавих хөндлөнгийн хяналт нэвтэрч, үйл ажиллагаа нь ил тод тунгалаг болж, зохистой засаглалын гол хүчин зүйл болох шийдвэр гаргах, гүйцэтгэх, хяналт тавих эрх мэдэл хуваагдаж, харилцан бие биедээ хяналттай, тэнцвэртэй эрх мэдэлтэй байх зарчим бий болж, дотоод хяналтын тогтолцоо хангагдана; нөгөө талаас олон

улсын стандарт, сайн туршлагад нийцсэн зохицуулалтын эрх зүйн орчин бүрдэж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлнэ; эдгээрийн үр дүнд гадаад дотоодын хөрөнгө оруулагч нарын банкинд итгэх итгэл нэмэгдэж, санхүүгийн зуучлал өргөжин гүнзгийрч, улмаар банкны систем эдийн засгийн урт хугацааны тогтвортой, хүртээмжтэй эерэг өсөлтөд зохих хувь нэмрээ оруулах болно гэж үзэж байгаа. Тус хөтөлбөрийн хүрээнд “Банкны салбарын хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, банкны үйл ажиллагааны зохистой засаглалыг сайжруулан ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай банкны тогтолцоог бий болгох Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТС) тогтолцооны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх, эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах, ФАТФ-ын саарал жагсаалтаас гарах, дараагийн харилцан үнэлгээнд бэлтгэх; Банкны үйл ажиллагааны чиглэл, бизнесийн загвар болон бусад онцлог хүчин зүйлд тулгуурлан банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, тавигдах шаардлагыг төрөлжүүлэн харилцагчид хүртээмжтэй, цахимжсан банкны тогтолцоог бий болгох; Банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишигт нийцүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн эрүүл, найдвартай банкны тогтолцоог бий болгох (Монголбанк, 2020) хэд хэдэн чухал зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Банкны шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр: Банкны хувь эзэмшлийн төвлөрөл буурснаар хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц төрөлжиж, өөрийн хөрөнгийн хүрэлцээг хангахад шаардлагатай эх үүсвэрийг олон нийтийн оролцоо, хяналттайгаар түргэн хугацаанд

төвлөрүүлэх боломжийг бүрдүүлж, зохистой засаглал сайжран харилцагч, хадгаламж эзэмшигч, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын банкинд итгэх итгэл нэмэгдэх, МУТС тогтолцоог боловсронгуй болгосноор МУТС-ын тогтолцооны хувьд үүссэн стратегийн дутагдлыг шийдвэрлэж, цаашид ФАТФ болон бусад олон улсын байгууллагаас хийх үнэлгээг сайжруулах, Банкуудын өөрийн хөрөнгө нэмэгдэж, банкны системийн эрсдэл даах чадвар сайжирснаар найдвартай, тогтвортой банкны тогтолцоо бүрдэж, эдийн засгийн урт хугацааны өсөлтийг дэмжих үр дүнгүүд бий болно гэж хүлээж байна (Монголбанк, 2020).

Банкны тогтолцооны шинэтгэлийн эрх зүйн үндсийг бий болгох зорилгоор банкны тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулан УИХ-аар хэлэлцэн 2021/01/29-нд баталсан байна. Тус хуульд “банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж банкны хувьцааны тав ба түүнээс дээш хувийг дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа этгээд, тэдгээрийн эцсийн өмчлөгч хүн, эсхүл банкны бодлого, шийдвэр болон удирдлагад нөлөөлөхүйц хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч хүнийг; “эцсийн өмчлөгч” гэж банкны үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг, эсхүл өөрийн энэ эрхээ бусдаар төлөөлүүлэн гүйцэтгүүлдэг, эсхүл банкны хувьцааг нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр дамжуулан эзэмшиж байгаа, тухайн хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан буюу банкны хувьцаа, үйл ажиллагаанаас үүсэх үр шимийг хүртэх эрх бүхий өмчлөгч хүнийг; “банкны системд нөлөө бүхий банк” гэж банкны хөрөнгө, өр төлбөрийн хэмжээ, төлбөрийн систем дэх гүйлгээний дүнд эзлэх хувь, банкны үндсэн үйл

ажиллагаа, санхүүгийн тогтолцоо дахь хамаарал зэрэг шалгуурыг нэгэн зэрэг баримтлан банкны тогтолцоонд нөлөөтэй гэж Монголбанкнаас тогтоосон банкуудыг хэлнэ” (УИХурал, 2021) гэж тодотгон зааж өгөөд, “Банкны системд нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат компани, бусад банк нь хувьцаат компанийн хэлбэртэй байна” (УИХурал, 2021) гэсэн агуулгатай заалтыг нэмж оруулсан байна. Мөн “аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны хэмжээ тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байна”, “банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж банкны хувьцааны тав ба түүнээс дээш хувийг дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа этгээд, тэдгээрийн эцсийн өмчлөгч хүн, эсхүл банкны бодлого, шийдвэр болон удирдлагад нөлөөлөхүйц хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч хүнийг”, “Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно” (УИХурал, 2021) гэсэн банкны шинэтгэлийн хөтөлбөрт чиглэсэн заалтууд нь банкны системийн эзэмшлийн давуу эрхүүдийг задалж, удирдлагын тогтолцооны төвлөрлийг багасгах цаашлаад манай улсын банкны системийг бүхэлд нь нээлттэй засаглалд чиглүүлсэн эрх зүйн үндэслэл болсон гэж харж байна.

Монголбанкнаас арилжааны банкуудын үйл ажиллагааг хянан шалгаж, нэгдсэн арга зүй, эрх зүйн бодлогоор хангаж ажиллахын зэрэгцээ банкуудын балансын болон үйл ажиллагааны үзүүлэлтүүдийг тодорхойлон харьцуулж, үнэлгээ хийн цаашдын бодлого төлөвлөлтийг тодорхойлоход ашигладаг. Банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөрийн


хүрээнд хийгдэж буй хяналт шалгалтын зохицуулалтын талаар товчхон дурдахад, бид олон улсын жишиг, зарчимд нийцүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын арга барилд шилжих арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Манай улсын хувьд Базелын цуврал стандартыг дотоодын банкны системийн онцлогт нийцүүлэн хэсэгчлэн нэвтрүүлж ирсэн бөгөөд цаашид Монголбанкнаас олон улсын сайн туршлагад үндэслэн Базел стандартын бүлэг 2-т тусгагдсан Хяналт шалгалтын үнэлгээний аргачлал (SREP)-ыг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан шат дараатайгаар нэвтрүүлэх ажлыг эхлүүлээд байна. SREP нь банкуудад учирч болзошгүй материаллаг түвшний эрсдэлүүдээс сэргийлэх

хангалттай хэмжээний өөрийн хөрөнгө, хөрвөх чадвартай байх шаардлагыг нэмэгдүүлж, зохистой засаглал болон эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулахыг зорьдог (Дөлгөөн, 2023).


Банкны хяналт шалгалтын дараах үзүүлэлтүүдийг ашиглан Монголын банкны системд нөлөө бүхий банкуудыг тодорхойлдог байна. Үүнд, нийт хөрөнгийн өгөөж, эздийн өмчийн өгөөж, цэвэр ашгийн маржин, чанаргүй зээлийн харьцаа. Эдгээр үзүүлэлт тус бүрээр зургаан банкныг харьцуулж Зураг 1-4-т үзүүлэв.

“Банкны системд нөлөө бүхий банк” гэж сүүлийн 6 сарын турш банкны системийн нийт активын 5 буюу түүнээс дээш хувийг эзэлж


Зураг 1. Нийт хөрөнгийн өгөөж, 2022 оны жилийн эцсийн байдлаар




Зураг 2. Эздийн өмчийн өгөөж, 2022 оны жилийн эцсийн байдлаар



Зураг 3. Цэвэр ашгийн маржин, 2022 оны жилийн эцсийн байдлаар



Зураг 4. Чанаргүй зээлийн харьцаа, 2022 оны жилийн эцсийн байдлаар



буй банкныг хэлэх ба Монголбанкнаас ХААН банк, Худалдаа Хөгжлийн Банк, Голомт банк, Төрийн банк, Хас банкуудыг нөлөө бүхий банкууд гэж тогтоосон байна. Эдгээр 5 банк нь Монгол Улсын банкны системийн 85 хувийг эзэлдэг бөгөөд банкны шинэтгэлийн хөтөлбөр, Банкны тухай хуулийн дагуу 2022/06/30-ны өдрөөс урьтаж нээлттэй хувьцаат компани болох ёстой байсан. Гэвч Олон Улсын Валютын Сангаас банкуудын активын чанарын үнэлгээг хийсний дараа нээлттэй хувьцаат компани болохыг зөвшөөрөх ёстой гэж Монголбанкинд зөвлөснөөр Монголбанк Улсын Их Хуралд хуулийн өөрчлөлтийн санал оруулж, хуулийн хэрэгжих хугацааг 2023/06/30-ны өдөр хүртэл сунгасан байна. Тус хугацааг сунгасантай

холбогдуулан гадаад, дотоодын оролцогч талуудыг бодит мэдээллээр хангах зорилгоор Монголбанкны санаачилгаар банкуудын активын чанар, эрсдэлийн сан болон өөрийн хөрөнгийн хүрэлцээг үнэлэх Активын чанарын хараат бус, хөндлөнгийн үнэлгээг олон улсад нэр хүнд бүхий аудитын компаниар гүйцэтгүүлсэн (Дөлгөөн, 2023). Банкууд үйлчлүүлэгчид зээл олгох үед, зээлийн барьцаа хөрөнгийн үнэлэгдэж байсан үнэлгээ хэрхэн өөрчлөгдсөнийг дүгнэдэг үзүүлэлтийг активын чанарын үнэлгээ (АОК) гэдэг бөгөөд активын чанарын хараат бус үнэлгээг 2022 оны 6 дугаар сараас 8 дугаар саруудад гүйцэтгэж, системд нөлөө бүхий 5 банкны нийт зээлийн багцын 70 орчим хувийг хамруулсан байна. Энэхүү

үнэлгээний үр дүнг нийтэд нээлттэй мэдээлсэн бөгөөд банкууд хувьцаагаа олон нийтэд нээлттэй гаргах зөвшөөрлөө Санхүүгийн зохицуулах хороо болон Монголбанкнаас авч үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхлээд байна. Олон улсын нийтлэг жишиг, сайн туршлагыг судласны үндсэн дээрээс том хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг багасгаснаар нэг этгээдийн нөлөөллийн хэт давамгай байдал буурч, бүх оролцогч талуудын ашиг сонирхолд нийцтэй шийдвэр гарах нөхцөл бүрдэж, засаглалыг сайжирч улмаар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр банк зөвхөн хувьцаат компани хэлбэртэй байхаар зохицуулсан. Банкны хувьцаа эзэмшлийн хувь хэмжээнд тавигдсан шаардлагыг биелүүлэх ажил үргэлжилж байгаа боловч богино хугацаанд уг шаардлагыг хангуулахад хувьцаанд хөрөнгө оруулах боломжит дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын бэлэн байдлын хувьд тодорхой эрсдэлүүд


үүсэж болзошгүй байна. Нийт арилжааны банкуудын хувьцаа эзэмшигчдийн төвлөрөл их байгаа ба ялангуяа нээлттэй хувьцаат компани хэлбэртэй байх системд нөлөө бүхий банкуудын хувьд хувьцааны төвлөрөл ойролцоогоор 55-95 хувьтай байна (Дөлгөөн, 2023).

Одоогийн байдлаар системийн нөлөө бүхий банкуудаас Төрийн банк, Голомт банкуудын хувьцааны анхдагч арилжаа хийгдсэн бөгөөд, хөрөнгийн биржээр хоёрдогч арилжаа нээлттэй явагдаж байна. ХААН банкны хувьцааны анхдагч арилжаа хийгдсэн төлөвт байна. Нөлөө бүхий банкуудаас Төрийн банк өөрийн хөрөнгийн 5%, Голомт банк 11.6%, ХААН банк 10% дээр тус тус олон нийтэд нээлттэй хувьцааг санал болгосон нь 5-10%-ийн хэлбэлзэлтэй байгаа бөгөөд цаашид 60-75%-ийн хувьцаагаа нэмж гаргах, эсвэл одоо байгаа хувьцаа эзэмшигчид өөрсдийн хувьцаагаа бусдад худалдах замаар банкны тухай хуульд


Хүснэгт 1. Хувьцааны арилжаатай холбоотой мэдээлэл

Үзүүлэлт	Төрийн	Голомт	ХААН
Нэгж хувьцааны үнэ	590.0	1,285.0	959.0
Олон нийтэд санал болгосон хувь (Өөрийн хөрөнгө)	5%	11.6%	10%
Санал болгосон нийт хувьцааны үнэ, сая.төг	22,100.0	103,300.0	183,400.0
Хувьцааны захиалгын биелэлтийн дүн, сая.төг	67,300.0	174,783.6	335,967.0
Хувьцааны захиалгын биелэлтийн хувь	304.5%	169.2%	183.2%

Зураг 5. Санал болгосон хувьцааны хувь хэмжээ



Зураг 6. Хувьцаа захиалгын биелэлт, хувиар



заасан нэг хувьцаа эзэмшигч 20% хүртэл эзэмшилтэй байх шаардлагыг хангах нөхцөл хүлээгдэж байна. Төрийн банк нэмж 14.3 хувийг худалдахаар төлөвлөж байгаа бөгөөд энэ төлөвлөлт хэрэгжвэл олон нийтийн эзэмшлийн хувь ойрын хугацаанд 20 хувьд хүрэх юм. Нээлттэй хувьцаа гаргасан банкуудын мэдээллийг Хүснэгт 1 болон Зураг 5-7-д нэгтгэж харуулав.

Эдгээр мэдээллээс харахад Төрийн банкны хувьцаа захиалгын биелэлт 304.5%-иар биелсэн нь хамгийн өндөр хувьтай байгаа үзүүлэлт хэдий ч хувьцаагаар татан төвлөрүүлсэн хөрөнгө нь 67.3 тэрбум төгрөг буюу бусад банкаас хамгийн бага хэмжээнд байна. Нөлөө бүхий таван банкны гурав нь өөрийн хөрөнгийн 8.8%-ийг дундажаар, нээлттэй хувьцааны арилжаагаар санал болгож банкны салбарт нийт 578 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг татаж чадсан байна. Одоогийн байдлаар Худалдаа хөгжлийн банк болон Хас банк нээлттэй хувьцаа гаргах зөвшөөрлөө СЗХ-с аваад байна. Ингэснээр Монголын банкны салбарын нөлөө бүхий таван банк бүгд нээлттэй хувьцаат компани болж зохион байгуулагдах эхний үе шат бүрэн хэрэгжих нөхцөл бүрдсэн байна.

### Дүгнэлт

Арилжааны банкуудын эзэмшил болоод засаглалд хийх гэж буй банкны шинэтгэл нь банкны удирдлага, хувьцаа эзэмшигчдэд таалагдахгүй байж болно. Гэвч энэ нь манай улсын ирээдүйд хийж буй том хөрөнгө оруулалт юм. Хөгжиж буй болон аж үйлдвэржсэн орнуудын банкны салбарын судалгаануудад үндэслэн эрх зүйн сайн тогтолцоог бүрдүүлэх нь Монголбанк, Засгийн газрын үүрэг бөгөөд энэ үүргийн хүрээнд банкны салбарт шинэтгэл хийж, шинэтгэлийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа билээ. Монголын банкны салбарт нөлөө бүхий банкуудаас одоогоор гурван банк нээлттэй хувьцаат компани болж зохион байгуулагдан хувьцаа гаргаснаар банкны өөрийн хөрөнгө нь 67.0 тэрбум, 174.8 тэрбум, 336.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Банкны өөрийн хөрөнгө нэмэгдсэнээр банкуудын үйл ажиллагаа зах зээлд илүү их тэлж, улсын эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөгөө төдий чинээгээр нэмэгдүүлэх боломжтой болох юм. Мөн банк нь нээлттэй хувьцаат компани болсноор засаглалын хувьд илүү сайжирч, ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргах нөхцлөөс ангижирч, үйл ажиллагаа тогтвортой явагдаж улмаар эдийн засгийн тогтвортой байдалд эерэгээр нөлөөлнө.



Энгийн иргэд банкны хувьцаа эзэмшигч болон, өгөөж хүртэх боломж бий болж байгаа нь банкны шинэтгэлийн хамгийн олзуурхах нөлөө юм.

Манай улсын сүүлийн 30 гаруй жилийн түүхэнд хамгийн өндөр өсөлттэй байгаа бизнесийн нэг нь банкны салбарын үйл ажиллагаа байсан. Энэ нь иргэд, хөрөнгө оруулагчид системийн нөлөө бүхий банкуудын найдвартай байдал, үйл ажиллагааны өсөлтөд итгэж, хөрөнгө оруулалтын өсөлт болон өгөөж өндөр байна гэсэн хүлээлтээр банкны хувьцааны арилжаанд өргөнөөр оролцсон үйл ажиллагаанаас тодорхой харагдаж байна. Нээлттэй хувьцаат компани болж зохион байгуулагдаж байгаа банкууд болон хувьцаагаар хөрөнгө оруулалт хийж буй иргэд аж ахуйн нэгжийн харилцаагаар дамжин Монголын хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг улам идэвхжүүлэн, хөрөнгийн зах зээлийн хөгжилд тодорхой нөлөө үзүүлэхүйц үйл ажиллагаа болж байгааг цохон тэмдэглэж байна. Нөлөө бүхий банкны жагсаалтад ороогүй ч Богд банк хувьцаа гаргасан анхны банк болсон бөгөөд татан төвлөрүүлэх өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхийн зэрэгцээ тэр хэрээр зах зээлийн эрэлт хэрэгцээнд шаардлагатай бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх боломжоо нэмэгдүүлэн өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэн, бататгах зорилготой байж болох юм. Тус банкыг хувьцаагаа нийтэд, нээлттэй гаргах үед нь зарим иргэд банкны тухай хуулийн хэрэгжилтийг нэр төдий үйл ажиллагаа болгох процесс гэж дүгнэж байсан юм.

2022 онд нээлттэй хувьцаат компани болсон банкууд 2022 оны тайлангийн үр дүнгээр хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг олгож эхэлсэн ба банкны

шинэчлэлтийн хөтөлбөрийн эхний үр дүнгүүд хэрэгжиж эхлээд байна. Тухайлбал Голомт банкны хувьд нэгж хувьцаанд 50 төгрөгийн ногдол ашиг олгох замаар нийт 40.0 орчим тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан байна. Харин Төрийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023/02/17-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор 2022 оны татварын дараах цэвэр ашгийн тавин хувийг нийт эргэлтэд байгаа 755,096,250 ширхэг энгийн хувьцааны нэгж хувьцаанд 63.68 (жаран гурван төгрөг жаран найман мөнгө) төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Нөлөө бүхий хоёр банкны хувьцаа гаргах үйл ажиллагаа ойрын хугацаанд хэрэгжих хүлээлт байгаа бөгөөд үүнд багадаа 162.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, цаашид олон нийтэд нээлттэй хувьцаа гаргах нөөц бололцоо байгаа эсэх нь эдгээр банкны хувьцаа арилжаанаас тодорхой болно гэж ажиглаж байна. Хувьцаа арилжааны биелэлт өндөр бөгөөд олон нийтийн сонирхол, оруулах хөрөнгийн бэлэн байдал хангалттай бол банкуудын засаглал, өмчлөлийн төвлөрөл хангалттай задлах явдал нь олон нийтэд нээлттэй арилжих хувьцааны хувь хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр байх болно. Үүнийг хуулинд 10 хувиас багагүй байна гэж заасныг нэмэгдүүлэх нь зөв байж болох юм. Мөн банкууд өөрийн хөрөнгийн 10 хувьд олон нийтэд хувьцаа арилжсан нь 741.0 тэрбум орчим төгрөгийн хүүгүй зээлийн эх үүсвэрийг тэр хэмжээгээр бүрдүүлж байгаа явдал юм. Тус эх үүсвэрийн нөлөөгөөр банкуудын зээлийн хувь хэмжээ буурах боломж бүрдэх ба үүгээр дамжуулан эдийн засагт нүүрлээд байгаа инфляцийн өсөлт буурах хандлагатай болно гэж дүгнэж байна.

Банкны реформыг хэрэгжүүлснээр банкны үйл ажиллагаа, тайлагнал Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээр хянан зохицуулагдах төдийгүй ил тод, нээлттэй болж, хяналтын тогтолцоо илүү боловсронгуй болох, хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өсөж, чанартай, хөрвөх чадвар өндөр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо нэмэгдэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх, оролцоо сайжрах, банкуудад урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэр бий болохоос гадна олон тулгуурт санхүүгийн тогтолцоог бий болгоход чухал алхам болох юм.

#### Ашигласан материал

- Fan, J. P. H., Wong, T. J. (2002). Corporate Ownership Structure and the Informativeness of Accounting Earnings in East Asia. *Journal of Accounting and Economics*, 33(3), 401-425.
- La Porta, R., Lopez-de-Silanes, F., & Shleifer, A. (1999). Corporate Ownership Around. *The Journal of Finance*, 54(2), 471-517.
- La Porta, R., Lopez-de-Silanes, F., Shleifer, A., & Vishny, R. (2002). Investor Protection and Corporate Valuation. *The Journal of Finance*, 57(3). 1147-1170.
- Баяраа, Т. (2023). *Монголбанк*. УБ хот: Өнгөт хэвлэл.
- Дөлгөөн, Г. (2023). *Банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна*. [www.news.mn](http://www.news.mn).
- Монголбанк. (2020). *Банкны шинэтгэлийн хөтөлбөр*. Банкны шинэтгэлийн хөтөлбөр.
- УИХурал. (2021). *Банкны тухай хууль*. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn).
- Цэрэнтоогоо, А. (2013). *Банкны менежмент I*. Улаанбаатар: Монгол Улсын Их Сургуулийн хэвлэх үйлдвэр.